



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**“ШҮҮГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДАЛД
ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ”- сэтгэл
зүйн судалгаа**

ТАЙЛАН

Шүүхийн ерөнхий
зөвлөлийн 2020 оны үйл
ажиллагааны
төлөвлөгөөнд тусгагдсан
ажлын хүрээнд бэлтгэв.

АГУУЛГА

УДИРТГАЛ ХЭСЭГ	2
НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
ХОЁР.СУДАЛГААНЫ ҮР ДҮН БОЛОВСРУУЛАЛТ	6
1. ШҮҮГЧИЙН СТРЕССИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ КЕССЛЕРИЙН АРГАЧЛАЛЫН ҮР ДҮН БОЛОВСРУУЛАЛТ	6
2. ШҮҮГЧИЙН АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖИЙГ ТОДОРХОЙЛОХ МАСЛАЧИЙН АРГАЧЛАЛЫН ҮР ДҮН БОЛОВСРУУЛАЛТ	8
ДҮГНЭЛТ	11
ХАВСРАЛТ	13
1. СТРЕССИЙН ТҮВШИНГ СУДЛАХ КЕССЛЕРИЙН АРГАЧЛАЛ.....	13
2. АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖИЙГ ТОДОРХОЙЛОХ МАСЛАЧИЙН АРГАЧЛАЛ.	14



УДИРТГАЛ ХЭСЭГ

1. Судалгааны зорилго ба хамрах хүрээ (судлах зүйл)

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс Шүүгчийн сэтгэл зүйн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор анхан болон давж заалдах шатны шүүгч нарыг хамруулсан болно.

Дээрх зорилгод үндэслэн шүүгчийн стрессийн түвшин болон ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох аргачлалыг боловсруулан судалгаа авч, үр дүнд тулгуурлан тайлан бичлээ.

Сэтгэл зүйн судалгаанд хамрагдах объектив хүчин зүйлс:

- Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тархалтай холбоотой сэтгэл зүйн судалгааг Google.forms.doc программ ашиглан цахим хэлбэрээр шүүгчдээс авах

Линк холбоос:

<https://docs.google.com/forms/d/1FWbXjevGuTGk1PMpBXyApLoQ3WuDV8Pc-TSltZWFxog/edit>

- Цахим судалгаанд хамрагдаагүй Улаанбаатар хотын шүүгч нараас цаасан хэлбэрээр нөхөж 9 дүгээр сард авав.
- Шүүгчээр ажилласан жил, эрх зүйн дагнасан төрөл нь шүүгчийн сэтгэл зүйн байдалд хэрхэн нөлөөлж буйг тодруулах
- Шүүгчийн нэр хүнд, хараат бус байдалд үл нөлөөлөх

Сэтгэл зүйн судалгаанд хамрагдах субъектив хүчин зүйлс:

- Хувь хүний сэтгэл хөдлөл, ачааллын тэнцвэртэй байдал
- Ажил мэргэжилдээ хандах хандлага
- Өөртөө итгэх итгэл, мэргэжлийн үнэлэмж, хараат бус байдал
- Харилцагчаа хүндэтгэх, ёс зүйн хэм хэмжээ
- Сэтгэл зүйн судалгаанд хамрагдах идэвх, хандлага
- Судалгааны үр дүнгийн нууцлалд итгэх итгэл
- Сэтгэл зүйн үйлчилгээг цаашид цахим хэлбэрээр үзүүлэхэд үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тооцох

Байгууллагын удирдлага, зохион байгуулалт:

- Шүүн таслах ажиллагааны төрөл, ажилласан жил, ажлын ачаалал зэргээс хамааран үүсэж буй Шүүгчийн сэтгэл зүйн асуудалд анхаарал хандуулах, мэдээллийн сан үүсгэх
- Судалгааны үр дүнг хувьчлан танилцуулж, анхаарах шаардлагатай Шүүгч нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
- Сэтгэл зүйн судалгааг тогтмол явуулж, шүүгчид албан ёсоор хамрагддаг байх

2. Судалгааны мэдээлэл цуглуулах арга

Судалгааны мэдээлэл цуглуулах аргачлалд Австралийн шүүхийн коллежийн судлаач нар болон олон улсад хэрэглэж буй Шүүгчийн стрессийн түвшин оношлох Кесслерийн аргачлал¹, ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох Маслачийн стандарт тест²-ийг тус тус ашигласан. Судалгааны нэгдүгээр үе шатанд Google.forms.doc программ ашиглан цахим хэлбэрээр, хоёрдугаар үе шатанд Улаанбаатар хотын судалгаанд оролцоогүй шүүгч нараас цаасан хэлбэрээр явуулав. Мэдээллийн нууцыг хадгалах, судалгааны үр дүн болон шаардлагатай зөвлөмжийг шүүгч өөрийн хүсэлтээр и-мэйл хаягаар авах боломжийг бүрдүүлсэн.

¹ Kessler Psychological Distress Scale /K10/ Source: Kessler R. Professor of Health Care Policy, Harvard Medical School, Boston, USA.

² Maslach C, Schaufeli WB, Leiter MP. Job Burnout. Annual Review of psychology 2001;52:397-422

3. Судалгааны онол аргазүй

- Стрессийн онол
- Сэтгэл хөдлөлийн онол
- Нийгэм-соёлын онол

4. Судалгааны түүвэр

Судалгааны түүвэр: Анхан болон давж заалдах шатны бүх шүүгч нараас нэлэхүй байдлаар судалгааны анхдагч мэдээллийг цуглуулав.

Мэдээллийн нууцлалыг хангах: Судалгааг Google.forms.doc программ ашиглан цахим хэлбэрээр болон цаасан хэлбэрээр биечлэн авсан бөгөөд судалгааны үр дүнг тухай шүүгчийн хүсэлтээр и-мэйл хаягаар илгээж, судалгааны үр дүнг нэгдсэн байдлаар боловсруулан тайланд тусгасан болно.

5. Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээллийг боловсруулсан байдал

Судалгааны мэдээллийг шүүгч нар аль болох бусдын нөлөөлөлд автахгүй, өөрийн үзэл бодлоо нээлттэй, чөлөөтэй илэрхийлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд мэдээллийн дан хийгээд харьцуулсан тоололтыг SPSS.23 for windows программ дээр боловсрууллаа.

6. Судалгааны ач холбогдол, үр нөлөө

- Шүүгч нарын сэтгэл зүйн байдалд дүн шинжилгээ хийх судалгааг эхний удаад стресс болон ажлаас халшрах хам шинж гэсэн 2 аргачлалаар авсан бөгөөд цаашид онлайн болон шууд хэлбэрээр тасралтгүй явуулах боломжийг бий болгосон.
- Шүүгчийн сэтгэл зүйн асуудлыг тодорхойлсон судалгааны нэгдсэн мэдээллийн сан үүсэх бөгөөд жил ирэх тусам шүүгч нарт үндэслэл тооцоотой, хэрэгцээгээ урьдчилан тодорхойлсон сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэхэд ахиц дэвшил болно.
- Монгол улсын хэмжээнд шүүгч нарын сэтгэл зүйн болон бие махбодод илэрч буй асуудлыг анхаарах, шүүгчийн амь насны даатгал болон бусад бодлогын түвшинд шийдэх шаардлагатай асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.


НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын хэмжээнд 2020 оны II улирлын байдлаар нийт 498 шүүгч ажиллаж байна. Судалгаанд өвчтэй, чөлөөтэй, томилолттой болон ээлжийн амралт авсан шүүгчид хамрагдаагүй болно. Эхний үе шат болох цахим судалгаанд 233 шүүгч судалгаанд сайн дураараа хамрагдсан. Хоёрдох үе шат болох Улаанбаатар хотын шүүгч нараас авсан цаасан хэлбэрийн судалгаанд 52 шүүгч хамрагдаж, нийт 285 шүүгч буюу нийт шүүгчдийн 57 хувь байна. Үүнээс Улаанбаатар хотын анхан болон давж заалдах шатны шүүгч 133 буюу 63 хувь, орон нутгийн шүүгч 152 буюу 53 хувь нь оролцсон. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг дараах хүснэгт, графикаар харуулбал:

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн байдал:

Үзүүлэлт	Тоололт	Хувь
Эрэгтэй	96	33.7%
Эмэгтэй	189	66.3%
Нийт	285	100%

График 1. Шүүгч нарын шүүхийн шатлал болон бүсчлэл:




Монгол улсын хэмжээнд давж заалдах шатны 112 шүүгч, анхан шатны 386 шүүгч шүүн таслах ажиллагааг явуулж байна. Эдгээр шүүгчдээс судалгаанд хамрагдсан байдлыг авч үзвэл давж заалдах шатны шүүгчдийн 45.5 хувь, анхан шатны шүүгчдийн 60.6 хувь нь судалгаанд идэвхтэй хамрагдсан байна.

Мөн шүүн таслах ажиллагааны төрлөөр авч үзвэл:

График 2.

Шүүн таслах ажиллагааны төрөл:



Судалгаанд хамрагдсан шүүгчдийн эрх зүйн дагнасан төрлөөр эзлэх хувийг тооцвол иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгч 36,5 хувь, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгч 32,3 хувь, захиргааны хэрэг хянан шийдвэрлэдэг шүүгч 17,9 хувь, эрүү болон иргэний хэрэг холимог шийдвэрлэдэг шүүгч 13,3 хувийг тус тус эзэлж байна.

Шүүгч нарын судалгаанд хамрагдах идэвх сонирхол бага байсан нь судалгааг давтан явуулах шалтгаан болсон. Ялангуяа Улаанбаатар хотын шүүгч нар сэтгэл зүйн судалгааны үр дүнтэй холбоотой сөрөг үр дагавар үүсэхээс болгоомжлон хувийн мэдээллээ нууцлах, судалгаа өгөхөөс татгалзах, сэтгэл зүйн асуудлаа үнэн зөв хариулахгүй орхих зэрэг бэрхшээлүүд гарч байлаа.

Шүүгчийн шүүгчээр ажилласан жил болон шүүн таслах ажиллагааны төрлөөс хамааран стрессийн түвшин, ажлаас халшрах хам шинж хэрхэн үүсэж байгааг судалгааны үр дүнгийн харьцуулсан хэсгээс харж болно.

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН БОЛОВСРУУЛАЛТ

1. ШҮҮГЧИЙН СТРЕССИЙН ТҮВШНИЙГ ТОДОРХОЙЛОХ КЕССЛЕРИЙН АРГАЧЛАЛЫН ҮР ДҮН БОЛОВСРУУЛАЛТ

Стрессийн түвшнийг тодорхойлох Кесслерийн аргачлал нь олон улсад шүүгчийн стрессийг тодорхойлж буй стандарт аргачлалуудын нэг юм. Энэ аргачлал нь стрессийн түвшин тодорхойлох 10 асуулгаас бүрдэнэ. Судалгааны үр дүнг боловсруулахад нийт шүүгчдийн 58,5 хувь нь хэвийн, 23,5 хувь нь бага зэрэг стресстэй, 14 хувь нь анхаарах шаардлага болон 4 хувь нь стресс өндөртэй гэсэн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл 118 шүүгч стресстэй байна гэсэн үг юм. Үр дүнг хүснэгт болон графикаар харуулбал:

График 3.

Шүүгчийн стрессийн түвшин:



Хүснэгт 2.

Стресстэй шүүгч нарын хувьд:

Шүүхийн шатлал	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
Анхан шат	46	51	97
Давж заалдах шат	7	14	21
Нийт	53	65	118

Стресстэй байгаа шүүгчдийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор шүүгчээр ажилласан жил, шүүн таслах ажиллагааны төрөл, газар нутгийн бүсчлэл зэргийг харьцуулан харвал:

Хүснэгт 3.

Шүүгчээр ажилласан жил болон Шүүгчийн стрессийн түвшний харьцуулалт:

Үзүүлэлт		Шүүгчийн стрессийн түвшин				Нийт
		Хэвийн	Бага зэрэг	Анхаарах шаардлагатай	Өндөр	
Шүүгчээр ажилласан жил	1-2 жил	27	5	7	0	39
	3-5 жил	19	16	4	2	41
	6-10 жил	43	14	10	1	68
	11-15 жил	27	11	9	3	50
	16-20 жил	25	4	5	4	38
	20-дээш жил	26	12	5	1	44
Бичээгүй		-	5	-	-	5
Нийт		167	67	40	11	285

Шүүгчийн стрессийн түвшинд анализ хийхэд 3-5 жил болон 6-10 ажиллаж буй шүүгч нарт стресс илүү илэрч байна. Энэ нь байнгын өндөр хариуцлага, ур чадвар шаардсан ажил мэргэжлийн онцлог, нийгмийн болон олон нийтийн хараа хяналт, гэр бүлийн амьдралын ачаалалтай үе зэрэг нөхцөл байдалд дасан зохицоход бэрхшээл үүсдэгтэй холбоотой юм. Стрессийн түвшин хэвийн байгаа 167 шүүгчээс 125 шүүгчид ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрч байна. /График 6-д тодорхой харуулсан болно/. Энэ нь шүүгч өөрийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хянаж, ажил мэргэжлийн онцлог гэж хүлээн авч чадаж байгаа хэдий ч ажлын ачаалал, хамтын ажиллагаа, шүүгчийн нэр хүнд, байр сууринаас бусдаас өөрийгөө тусгаарлах, сэтгэл хөдлөлөө нуух, аливаа үйлдэлд хэт болгоомжлох, нэгэн хэвийн амьдралын хэмнэлд орох зэрэг хувь хүний сэтгэл зүйн хязгаарлагдмал нөхцөл бий болсон байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Шүүн таслах ажиллагааны төрөл болон шүүгчийн стрессийн түвшин:

Шүүн таслах ажиллагааны төрөл	Шүүгчийн стрессийн түвшин				Стресстэй шүүгчид		Нийт	
	Хэвийн	Бага зэрэг	Анхаарах	Өндөр	Тоололт	Хувь	Тоололт	Хувь
Иргэний хэрэг	54	31	14	5	50	48%	104	36.5%
Эрүүгийн хэрэг	61	18	12	1	31	33.6%	92	32.3%
Захиргааны хэрэг	31	10	8	2	20	39.2%	51	17.9%
Эрүү болон иргэний хэрэг	21	8	6	3	17	44.7%	38	13.3%
Нийт	167	67	40	11	118		285	100%

График 4. Стресстэй байгаа шүүгчийн зураглалыг харуулбал:



Шүүн таслах ажиллагааны төрлөөр ангилан авч үзвэл Улаанбаатар хот болон орон нутгийн иргэний хэргийн шүүгч нар бусад шүүгч нараас илүү стресстэй байна. Өөрөөр хэлбэл иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны 104 шүүгч судалгаанд оролцсоноос 48 хувь нь стресстэй байна. Үүн дотор Улаанбаатар хотын шүүгч нар илүү давамгайлж байгааг дээрх графикаас харж болно. Харин орон нутгийн эрүү, иргэний хэрэг холимог шийддэг шүүгч нарын 44.7 хувь нь стресстэй байна.

2. ШҮҮГЧИЙН АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖИЙГ ТОДОРХОЙЛОХ МАСЛАЧИЙН АРГАЧЛАЛЫН ҮР ДҮН БОЛОВСРУУЛАЛТ

Калифорний их сургуулийн сэтгэл судлалын профессор Кристина Маслачийн боловсруулсан халшрах хам шинжийг үнэлэх стандарт тестийг ашиглан судалгааг явуулсан. Энэхүү тест нь ажлаас халшрах хам шинжийг үнэлэх 3 хэмжигдэхүүнтэй. Үүнд:


- 1) Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт
- 2) Ажлаа сэтгэлээсээ мэдрэх чадвар буурах
- 3) Хувь хүний бүтээмж буурах гэсэн шинжүүд хэрхэн илэрч байгаагаар ажлаас халшрах хам шинжийг тодорхойлдог.

Судалгаанд оролцогчдын ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлтийг дараах хүснэгт, графикаар харуулбал:

Хүснэгт 5. *Ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлт:*

Үзүүлэлт	Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт		Ажлаа сэтгэлээсээ мэдрэх чадвар буурсан		Ажлын бүтээмж буурсан		Ажлаас халшрах хам шинж	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Шинж тэмдэг								
Бага	195	68.7%	49	17.2%	101	35.6%	51	18%
Дунд	76	26.7%	197	69.4%	146	51.4%	183	64.4%
Дундаас дээш	13	4.6%	27	9.5%	30	10.5%	39	13.7%
Өндөр	0	0	11	3.9%	7	2.5%	11	3.9%
Хариулаагүй	1		1		1		1	

График 5. *Ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлт:*



Судалгаанд оролцогчдын 18 хувь нь ажлаас халшрах хам шинж бага, харин 82 хувь нь ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрч байна.


Судалгааны үр дүнг боловсруулах явцад шүүгчийн сэтгэл хөдлөл, ажлаа сэтгэлээсээ мэдрэх чадвар, хувь хүний бүтээмж зэрэг үзүүлэлтүүд харилцан адилгүй байгаа ч ажлаас халшрах хам шинж нийтлэг байдлаар үүссэн байгаа нь ажиглагдсан болно. Мөн стрессийн түвшин хэвийн байгаа боловч ажлаас халшрах шинж өндөр

үзүүлэлттэй байгаа шүүгч нар цөөнгүй хувийг эзэлж байна. Үүнийг дараах хүснэгт болон графикаар харуулбал:

Хүснэгт 6. Стресс болон Ажлаас халшрах хам шинжийн хамаарал:

Стресс	Ажлаас халшрах хам шинж				Нийт
	Бага	Дунд зэрэг	Дундаас дээш	Өндөр	
Хэвийн	42	108	14	3	167
Бага зэрэг	8	46	10	3	67
Анхаарах шаардлагатай	2	26	11	1	40
Өндөр	0	3	4	4	11
Нийт	52	183	39	11	285

График 6. Шүүгчийн стресс болон ажлаас халшрах хам шинжийн хоорондын хамаарал:



Энэ нь шүүгч өөрийн сэтгэл зүйн тэнцвэртэй байдлыг хадгалах чадвартай байгаа хэдий ч ажлын хэт их ачаалал нь сэтгэл хөдлөл болон ажилдаа хандах хандлага, бүтээмжид сөргөөр нөлөөлж байгаа нь 74,8 хувьд илэрч байна.

Шүүгчийн ажлаас халшрах хам шинжийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөр авч үзвэл:


Хүснэгт 7.

Шүүгчийн ажлаас халшрах хам шинж:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл болон бүсчлэл	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг		Захиргааны хэрэг		Иргэн, эрүүгийн /холимог/		Нийт
	Анхан шат	Давж заалдах шат	Анхан шат	Давж заалдах шат	Анхан шат	Давж заалдах шат	Анхан шат	Давж заалдах шат	
Улаанбаатар хот	44	2	35	4	18	10	-	-	113
Орон нутаг	34	1	26	6	21	-	15	17	120
Нийт	78	3	61	10	39	10	15	17	233

График 7. Ажлаас халшрах хам шинж болон хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны төрөл:



ДҮГНЭЛТ

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс шүүгчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын хэмжээнд шүүн таслах ажиллагааг явуулж буй давж заалдах болон анхан шатны шүүгч нарыг хамруулан 2020 оны 6 дугаар сар болон 9 дүгээр сард 2 үе шаттайгаар явуулсан. Эхний үе шатанд Google.forms.doc програм

[https://docs.google.com/forms/d/1FWbXjevGuTGk1PMpBXyApLoQ3WuDV8Pc-](https://docs.google.com/forms/d/1FWbXjevGuTGk1PMpBXyApLoQ3WuDV8Pc-TSItZWFxog/edit)

[TSItZWFxog/edit](https://docs.google.com/forms/d/1FWbXjevGuTGk1PMpBXyApLoQ3WuDV8Pc-TSItZWFxog/edit) онлайн хэлбэрээр зохион байгуулсан. Энэ судалгаанд Улаанбаатар хотын анхан болон давж заалдах шатны шүүгчид оролцоо бага байсан учир судалгааны хоёр дахь үе шатыг явуулсан.

Монгол улсын хэмжээнд шүүгчээр томилогдон ажиллаж буй давж заалдах болон анхан шатны шүүгч нарын орон нутгийн нийт 295 шүүгчээс 152 шүүгч буюу 53 хувь, Улаанбаатар хотын нийт 203 шүүгчээс 133 шүүгч буюу 63 хувь нь хамрагдсан.

Шүүгчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох судалгааны аргачлалыг Австралийн шүүхийн коллежийн судлаач нарын санал болгосон хэд хэдэн аргачлалыг орчуулан боловсруулсан бөгөөд эхний удаад 1. Стрессийн түвшинг тодорхойлох Кесслерийн аргачлал, 2. Ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох Маслачийн аргачлал тус тусыг сонгон авч ашигласан болно. Мөн цаашид сэтгэл зүйн судалгааг Google.forms.doc ашиглан тогтмол явуулах боломжтой бөгөөд судалгааны үр дүнг шүүгчийн өөрийн хүсэлтээр и-мэйл хаягаар илгээж, шаардлагатай шүүгч нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгөх эргэх холбоог энэхүү судалгааны явцад бий болгосон. Судалгаанд оролцсон 210 шүүгч өөрийн сэтгэл зүйн судалгааны үр дүнг и-мэйл хүлээн авахыг хүссэн нь талархууштай байна.

Судалгааны үр дүнг дүгнэвэл:

- Стрессийн түвшнийг тодорхойлох судалгааны үр дүнд нийт шүүгчдийн 58,5 хувь нь хэвийн, 23,5 хувь нь бага зэрэг стресстэй, 14 хувь нь анхаарах шаардлага болон 4 хувь нь стресс өндөртэй гэсэн үзүүлэлттэй байна. Стресстэй байгаа шүүгчийн сэтгэл зүйн болон ажил амьдралд үүсэж буй асуудлыг тодруулах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллана.
- Шүүгчээр ажилласан жилээр харьцуулан авч үзэхэд 3-15 жил ажиллаж буй шүүгч нарт стресс илүү илэрч байна. Энэ нь шүүгч ажлын ачаалал, хувийн амьдралын асуудал аль алиныг нь тэнцвэртэй авч явахад зайлшгүй хүчин чармайлт гаргах хэрэгцээ үүсдэг болох нь шүүгч нартай ярилцах үед илэрч байсан.
- Шүүн таслах ажиллагааны төрлөөс хамааран хувь хүний зан араншин, харилцааны онцлог ялгаатай байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байсан бөгөөд стрессийн түвшин нь иргэний хэргийн шүүгч нарын 48 хувь, эрүү, иргэний хэрэг холимог байдлаар шийддэг шүүгч нарын 44,7 хувь байгаа нь бусад төрлийн хэрэг шийддэг шүүгч нараас илүү стресстэй байгааг харуулж байна.
- Ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох судалгааны үр дүнгээр нийт шүүгч нарын 18 хувь нь ажлаас халшрах хам шинж бага, харин 82 хувь нь ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрч байна.
- Мөн стрессийн түвшин хэвийн байгаа 167 шүүгчээс 125 шүүгчид ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрч байна. Энэ нь шүүгч өөрийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хянаж, ажил мэргэжлийн онцлог гэж хүлээн зөвшөөрдөг хэдий ч ажлын ачаалал, хамтын ажиллагаа, шүүгчийн нэр хүнд, байр суурь нь бусдаас өөрийгөө тусгаарлах, сэтгэл хөдлөлөө нуух, аливаа үйлдэлд хэт болгоомжлох, сэтгэл

зүйн хамгаалалт үүсгэх, нэгэн хэвийн амьдралын хэмнэлд орох зэрэг хувь хүний сэтгэл зүйн хязгаарлагдмал нөхцөл бий болж, ажил мэргэжилдээ хандах хандлагад нөлөөлж байна.

- Улаанбаатар хотын хувьд шүүгчийн ажлын ачааллыг бууруулахын тулд дутуу байгаа орон тоонд шүүгч нарыг томилох, шүүхийн захиргааны ажилтны хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, шүүгчийн ажиллах орчныг сайжруулах зэрэг асуудлыг шийдэх нь шүүгчийн стрессыг бууруулах болон ажлыг бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал гэдгийг шүүгч нар санал болгож байна.
- Сэтгэл зүйн судалгааг онлайн хэлбэрээр авахад шүүгч нарын оролцох идэвх Улаанбаатар хотод учир дутагдалтай байсан учир давтан цаасан хэлбэрээр явуулсан болно. Улаанбаатар хотын шүүгч нар судалгаанд оролцохдоо хувийн мэдээллээ нууцлах, судалгаанд оролцохоос татгалзах, судалгааны үр дүнгээс ирээдүйд үүсэх эрсдэлийг нягтлах зэрэг маш их болгоомжлол үүсгэж байж энэхүү судалгаанд оролцсон болохыг анхааруулж байна. Иймд судалгааны үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэхийг хориглож байна.



ХАВСРАЛТ

1. Стрессийн түвшнийг тодорхойлох Кесслерийн аргачлал /K10/

Заавар: Дараах асуултын нөхцөлүүд сүүлийн 30 хоногийн хугацаанд таны бодол, мэдрэмж, үйл ажиллагаанд хэрхэн илэрч буйг тодорхойлно уу. Зөв болон буруу хариулт гэж байхгүй тул өөрт бодогдож байгаагаар хариулахад болно. Нэг өгүүлбэрт нэг хариулт тэмдэглэнэ үү.

1. Танд ямар ч шалтгаангүйгээр ядарсан мэт санагдах тохиолдол хэр их гардаг вэ?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

2. Уурлах, цухалдах мэдрэмж чамд хэр их үүсдэг вэ?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

3. Уурлаж цухалдсан үед таныг юу ч тайвшруулж чадахгүй мэт тайван бус байдал үүсдэг үү?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

4. Ямар ч итгэл найдвар байхгүй мэт санагдах үе гардаг уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

5. Огт амрахгүй байгаа мэт санагдаж, саяхны зүйлээ ч тогтоохгүй амархан мартаад байгаа мэт санагддаг уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

6. Анхаарлаа төвлөрүүлэхэд хэцүү, нэг суудал дээрээ ч тогтоход бэрхшээлтэй байх үе танд гарч байна уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

7. Амархан хямарч, бүх зүйл болж бүтэхгүй, чаддаг байсан зүйлээ ч чадахгүй мэт санагдах үе танд гардаг уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

8. Бүх зүйлийг хичээл зүтгэл гаргаж байж хийх хэрэгтэй мэт санагддаг уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

9. Юу ч таныг баярлуулж чадахгүй мэт уйтгарлах үе гардаг уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

10. Бусдад огт үнэлэгдэхгүй, үнэ цэнэ үгүй мэт мэдрэмж төрж байна уу?				
1. Огт үгүй	2. Хааяа	3. Зарим үед	4. Ихэвчлэн	5. Үргэлж

2. Ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох Маслачийн асуулга

Заавар: Асуулгын бодомж бүрд өөрийн мэдрэмжийн дагуу удаан бодолгүй, өөрт төрсөн анхны сэтгэгдлээр хариулна уу.

Бодомжууд	Огт үгүй	Хааяа	Ихэвчлэн	Өдөр бүр
1. Ажлын 7 хоногийн эцэст би өөрийгөө маш их ядарсан, хоосорсон мэт мэдэрдэг.				
2. Орой гэхэд би өөрийгөө шахсан лимон мэтээр мэдэрдэг.				
3. Өглөө болохдоо унтаагүй, ядарсан, ажилдаа явах ёстой гэсэн бодолтой сэрдэг.				
4. Өдөржин хүмүүстэй ажиллах нь миний хувьд дарамт юм.				
5. Хамт ажилладаг хүмүүсээсээ би залхаж байна.				
6. Би өөрийгөө маш эрч хүчтэй, өөдрөгөөр мэдэрч байна.				
7. Би ажил дээрээ хэт их ажиллаж байгаа юм шиг санагдаж байна.				
8. Би сүүлийн үед хайхрамжгүй болсон.				
9. Хамт ажиллаж буй хүмүүстээ би эерэг нөлөө үзүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлдэг.				
10. Би үйлчлүүлэгчдийн аливаа зүйлд ямар сэтгэгдэлтэй байгааг амархан ойлгодог.				
11. Би ямар ч хүнд асуудалд оновчтой шийдвэр гаргадаг.				
12. Би өөрийнхөө ажлаар дамжуулан бусад хүмүүсийн амьдралд эергээр нөлөөлж буйгаа мэдэрч байна.				
13. Би амьдралд улам урам хугарах болсон.				
14. Би харилцагчидтайгаа тайван уур амьсгалыг бий болгож чадна.				
15. Би хамт олонтойгоо нягт хамтран ажилласны дараа баяр баясгаланг мэдэрдэг.				
16. Би энэ ажилд олон үнэ цэнтэй зүйлийг хийж чадсан.				
17. Ажил дээр үүссэн сэтгэл санааны асуудлыг маш тайван байдлаар шийддэг.				
18. Зарим харилцагч нарыг "объект" мэтээр хандах мэдрэмж төрдөг.				
19. Энэ ажлыг гардан авснаас хойш би хүмүүст илүү хүйтэн хандах болсон.				
20. Энэ ажил намайг сэтгэл санааны хувьд хатуу болгож байна гэж санаа зовж байна.				
21. Зарим үйлчлүүлэгчийн хувьд ямар нөхцөл үүсэх нь надад огт хамаагүй.				
22. Үйлчлүүлэгчид маань өөрсдийн асуудлаараа намайг буруутгаж буй мэт санагдаж байна.				

Тайлан боловсруулсан:
Хянасан:

ШСМСХ-ийн сэтгэл зүйч Б.Нямаа
ШСМСХ-ийн захирал Б.Айбек